МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 25 өдөр    Дугаар А/223    Мандалговь

Гэрээ байгуулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль" –ийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын 2018 оны А/14 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Барилгын материалын чанарт хяналт тавих лабораторийн тоног төхөөрөмж" нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр "Монобилка" ХХК-ийг сонгон 54,000,000 (тавин дөрвөн сая) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан тодорхойлолтын дагуу тоног төхөөрөмжийг хүлээлгэж өгөхийг "Монобилка" ХХК-ний захирал (А.Баян-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА    О. БАТ-ЭРДЭНЭ

0200652